



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 1796

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.8, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.4, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд жуулчид мэдээлэл авдаг томоохон цахим хуудсууд болох [www.wikipedia.com](http://www.wikipedia.com), [www.wikitavel.org](http://www.wikitavel.org) дахь Улаанбаатар хотын мэдээллийг шинэчлэх, шинээр боловсруулах ажлыг “Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо”-той хууль, журамд нийцүүлэн гэрээ байгуулж гүйцэтгүүлэхийг Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /Б.Халиун/-д үүрэг болгосугай.

2. Гэрээт ажлын төлбөр болох 9.500.000 /есөн сая таван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА